· Сонгогч санал авах байранд оорийн биеэр ирж, иргэний vнэмлэх, эсхvл vндэсний гадаад паспортыг сонгогчдын нэрийн жагсаалттай тулгуулан шалгуулсны дараа саналын хуудсаа дугтуйн хамт авч, санал бэлтгэх бvхээгт саналаа нууцаар гаргана.

· Сонгогч нь саналын хуудсанд оорийн дэмжиж байгаа зовхон нэг нам эсхvл эвслийн нэрийн омнох улаан хvрээ бvхий дугуйг зориулалтын vзгээр дvvргэн будаж саналаа тэмдэглэсний дараа саналын хуудсыг дугтуйд хийн битvvмжлэн нааж, саналын хайрцагт хийнэ.

· Сонгогч саналаа тэмдэглэхдээ алдаа гаргасан бол дугтуйлсан саналын хуудсаа саналын хайрцагт хийхээс омно Салбар комисст мэдэгдэж, уг хуудсаа хураалгаж, дахин нэг удаа саналын хуудсаа авч саналаа гаргаж болно.

· Нэгээс илvv нам, эвслийн толоо санал огсон бол Таны санал хvчингvй болно гэдгийг анхаарна уу.

· Харин саналын хуудсан дахь зааварт зааснаас оор тэмдэглэл хийсэн тохиолдолд саналын хуудас хvчингvй болно.

- **Сонгогчдод хориглох зvйл:**

- Хуурамч болон оор хvний бичиг баримт ашиглаж санал огох, санал огохийг оролдох, хуурч мэхлэх:

- Санал авах байранд гаднаас саналын хуудас авч орох, авч гарах:

- Саналын хуудсанд хийсэн тэмдэглэгээгээ бусдад харуулах, зураг авах, дvрс бичлэг хийх.

**Гадаад улсад байгаа сонгуулийн эрх бvхий иргэдийн саналыг авах**

**ажлыг зохион байгуулах КОМИСС**

**МОНГОЛ УЛСЫН СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРОО**

**www.gec.gov.mn**

Санал авах байрны хаяг:

Утас: